



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/17

Хэрлэн сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын цахилгааны шугам сүлжээ, Дэлгэрхаан суманд Монголын нууц товчоо цогцолборын барилгын гадна цахилгаан хангамжид 10кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 10/04 кВ-н хүчдэлтэй 250 КВа-н чадалтай дэд станцын угсралтын ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Э.Мөнх-Эрдэнэ Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: И.Баасанжав Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн


Гишүүд: Б.Сандагдорж Багануур Зүүн өмнөд бүсийн Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-н Хэнтий аймаг дахь салбарын инженер

Х.Гонгор Иргэний төлөөлөл

Д.Оюун Төрийн бус байгууллагын төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

23101013'